

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар

8/25

Сүмбэр сум

“Ковид-19” цар тахлын халдвараас
урьдчилан сэргийлэх талаар авах зарим
арга хэмжээний тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар 103.1, 103.3 дахь заалт, Улсын онцгой комиссийн 2020 оны 12 дугаар сарын 19-ны 3728 дугаар албан тоот зэргийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан албан хаагчдын 30 хүртэлх хувийг ажлын байранд ажиллуулж, 0-5 хүртэлх настай хүүхэдтэй ажилтан албан хаагчдыг албан үүргээ гэрээсээ цахимаар ажиллуулсугай.

2.Нийт албан хаагчдийн 30 хүртэлх хувийг ажлын байранд ажиллах ажилтнуудын цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.


3.Ажилтнуудын цахим болон богиносгосон цагийг үндсэн цагаар ажилласанд тооцож цалинжуулахыг ня-бо /Б.Лүнгэрэгжанцан/-т зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Биеийн тамир спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах албаны дарга /М.Батдэлгэр/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР-ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.БУЯНТОГТОХ



Биеийн тамир, спортын газрын даргын
2020 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн
12 дугаар тушаалын хавсралт



АЖИЛТНУУДЫН АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

№	Эхлэх цаг	Цайны цаг	Дуусгах цаг	Ажиллах цаг
1	09.30	12.30-13.30	13.30-16.30	6 цаг